



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/656

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3, 4.1, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 23 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Статистикийн алба байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд салбарт хамтран ажиллаж буй аймгийн удирдлагууд, багийн Засаг дарга, сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтнүүдэд хүн ам, өрхийн мэдээллийн сангийн шинэчилсэн программын сургалт, зөвлөгөөний арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах зардалд 10,000,000 (Арван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээр зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Г.Гандэлгэр)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Гансүх)-д үүрэг болгосугай.



ДАРГА

ТӨМӨРБААТАР